

ТӨВ АЗИЙН ОЛОН УЛСЫН СОЁЛЫН ХАРИЛЦААНЫ ЭРТНИЙ ТҮҮХЭЭС

А. ДАМДИНСҮРЭН түүхийн ухааны дэд эрдэмтэн

Төв Азид нэн эрт цагаас эхлэн олон тооны харилцан адилгүй янз бүрийн овог, аймаг, улс гүрнүүд төр улс байгуулан оршин тогтнож ирэхдээ өөрсдийн өвөрмөгц аж ахуй, соёл иргэншлийг цогцлон байгуулж бие даан хөгжиж ирсэн өнө эртний түүхэн уламжлалтай билээ.

Тэдгээр улс орнууд нь харилцан бие биетэйгээ эдийн засаг, соёлын талаар өргөн харилцаж байсан нь аливаа овог аймаг, улс орны дотор шинээр буй болсон эдийн засаг, соёл, оюуны ололтуудын дотроос аль ашигтай, дэвшилттэй сайн зүйлс нөгөө бусад улс орны дотор ямар нэг замаар нэвтрэн дэлгэрч түүхийн бүхий л үеийн турш газар нутгийн алс хол оршиж байгааг харгалзахгүйгээр улс түмнүүд бие биедээ харилцан нөлөөлөхөд дөхөм болж иржээ. Тэдгээрийн зарим нь он жилийн уртад аль улс орноос үүсэн гарсан нь тодорхой мэдэгдэхгүй болдог тал бий боловч ямар нэг замаар бусад улс оронд нөлөөлөн дэлгэрсээр уг бүтээл нь мөхөгдөггүй үеийн үед уламжилдаг сайхан жамтай.

Дорнодахины түүх сударт тэмдэглэгдсэн баруун орнууд (Сиюй) болон Ху (Хүннү) зэрэг орнууд нь үнэхээрийн баян, тансаг, гайхамшигт олон зүйлүүдийг тухайн үедээ бүтээж бий болгосон нь өрнө, дорнын улсуудын анхаарлыг татаж байснаас, Хятадын Хан улс тэдгээрээс ямар ямар зүйлүүдийг авч өөртөө нэвтрүүлсэн тухай баримтууд Хятадын эртний сурвалж бичигт тэмдэглэгдэн үлдэснийг үндэс болгон хойно өгүүлсүгэй.

Тухайн үед соёл иргэншил цэцэглэн хөгжиж байсан аливаа улс орон, ард түмэн нь өөрсдийн оюун ухаан, хөдөлмөрөөр буй болгон бүтээсэн тэрхүү сонин хачин, гайхамшигт зүйлээрээ бахархдаг. Тийм зүйлийн зарим нь уг бий болгон бүтээсэн улс орондоо тэр бүрий үүрд уламжлан хадгалагддаггүй байв. Түүхийн урт удаан хугацаанд тэр улс гүрэн нь түүхэн янз бүрийн учир шалтгаанаас болж мөхөж сөнөх явдал цөөнгүй тохиолддог байв. Харин тэр ард түмний оюун ухаанаар бүтэж буй болсон зүйл нь уг улс оронтойгоо хамт мөхөж үгүй болдоггүй билээ. Японы түүхчин Хатана-рётай бичихдээ «Хятадаас баруун зүгийн орнуудтай улс төрийн талаар харилцах явдал нь Хан улсын уди хааны үеэс (МЭӨ III зуун) эхэлж, зам харилцаа бий болсон. Энэ нь баруун орнууд, хятад хоёрын харилцаанд зуучлагч нь Хүннү улс болж байв»¹ гэж бичээд У Ди хаанаас (МЭӨ 140—136 он) баруун орнуудтай харилцаа холбоо тогтоож байгаа нь нэг талаар Хүннү нарын талаар явуулж байсан бодлоготой холбоотой, нөгөө талаар бүхэлдээ харь газрын ховор нандин эрдэнэсийн зүйлсийг олж авах зорилготой² байв гэсэн байдаг. Энэ зорилгоо биелүүлэхээр Уди хаан зарлиг буулган Чжан Цзянь-ийг МЭӨ 140—139 онд баруун орнууд руу ийнхүү элчээр явуулжээ. Чжан Цзянь ийнхүү баруун орнуудаар явахдаа олзлогдсон Ху-хүннү хүн Танифуг хэлмэрч,

газарчаар авч 100 гаруй хүн дагуулан гарчээ. Түүнээс өмнө Хан улс нь баруун орнуудыг огт мэдэхгүй байсан, энэ үеэс эхлэн олзлогдсон Танифуг ашиглан Хятадын элч Чжан Цзянь баруун орнуудад хүрч очиход болон хан улс, баруун орнуудын хооронд харилцаа тогтоох, баруун орнуудад тэр үед цэцэглэн хөгжиж байсан соёл иргэншлийн ололт амжилттай танилцахад Танифуг ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Хэрэв Хүннү хүнээр хэлмэрчлүүлэн газарчлуулж яваагүй бол Хятадын элч Чакан Цзянь тийшээ тийм амархан нэвтэрч чадахгүй байсан.

МЭӨ III зууны сүүлчээр баруун орны 26 улс хүннү нарын харьяанд орсон байв. Иймд эдгээр оронд Хүннү нарын нөлөө маш их байжээ. Чжан Цянь баруун орнуудаар явж ирээд хаандаа айлтгасан нь: «Усуниэс Аньси хүртлэх орнууд Хүннүгийн Шаньюйн гэрэгэтэй элч нарыг дотночлон үзэж, уналга хүнсээр хангах мөртлөө мөнгө зоос өгөхгүй бол бидэнд ер юм олдохгүй байлаа»³ гэж бичсэн байдаг. Үүнээс үзэхэд тэдгээр оронд Хан улсын нөлөө нэвтрээгүй, харин Төв Ази болон баруун орнуудын соёл иргэншлийн нөлөө Хан улсад илүү их нэвтэрч байв. Хан улсын үед баруун Ху нарын ноолуурын даавуу, Ху нарын хонины ноосоор урлан хийсэн даавуу нь тус тус Хятад оронд орж ирж байжээ.⁴

Баруун зүгийн улс орнуудад ноосон нэхмэл эдлэл үйлдвэрлэн гаргадаг улс орон олон байжээ. Хан улсын уди хаан өөрийн элч Су У-г Хүннү рүү илгээж байсан юм. Хан улс чухам эндээс Хүннү нарын эсгий яаж хийж байсныг мэдэж авсан байна. МЭӨ 73-69 оны үеийн мэдээгээр Хүннү нар эсгийгээр хийсэн олбог дэвсгэртэй, нэхийгээр бүрсэн урин овоохой—майханууд нь довтолгод лугаа адил их хэмжээгээр бөөгнөрсөн байв гэж бичсэнээс үзэхэд тэр үед Хүннү нар олон төрлийн ноосон нэхмэл эдлэл их хэмжээгээр боловсруулсан байсныг үүнээс мэдэж болох юм гэсэн байдаг.⁶ Хүннүгийн захиргаанд тэр үед байсан усунь нарын сууж байсан орон байр нь эсгий туургатай гэр байжээ.⁷ Кушаны урлан бүтээсэн нэхмэл эдлэл ч мөн ихээхэн алдартай байв. Хятадын Хан улсын бичгийн түшмэл Вангу бичсэн захидалдаа: «Хан улс 300 толгой цагаан торгоор Кушан гүрнээс морь, хүж, олбог дэвсгэр худалдан авахаар тохиролцож байсан» гэж өгүүлжээ.⁹ Кушаны олбог дэвгэр нь том, жижиг, янз бүрийн хэмжээтэй байсан төдийгүй, нарийн аргаар бүтээсэн сайн чанарын эд байжээ. Ухуань аймагт эмэгтэйчүүд олбог дэвсгэрийг нэхэж хийдэг байжээ.¹⁰

Тэр үед Ромын эзэнт гүрэнд нэхмэл эдлэлийг маш нарийн ур хийцтэй, өнгө үзэмж төгөлдөр сайхан бүтээгдэхүүнийг маш их хэмжээгээр үйлдвэрлэн гаргадаг байжээ. Ромын эзэнт улс нь хонины ноос, модны холтос, зэрлэг хүр зэргийг ашиглан тав болон есөн энгийн нэхмэл эд хийдэг энэ нь хувцас хийх материал болдог тул хүмүүсийн анхаарлыг ихэд татдаг байжээ.¹¹ Ромынхан нэхмэл эдлэлээ ийнхүү алс хол газраас авчирч байснаас гадна тэдгээрийг хийх технологийн арга ажиллагаа нь мөн дагалдан иржээ. Үүний баримт нь Төв Азиас Грек, Ромын нэхмэл-

3. Мөн тэнд

4. Чэнь Чжунун, Лян хэнхэ, Сиюй дэн диды цзинци вэньхуа цзяолю, Шанхай. 1957 (Культурные и экономические связи Китая с западом в период ханской династии (7-12, 18, 19-р тал)

5. Мөн тэнд

6. Мөн тэнд

7. Мөн тэнд

8. Мөн тэнд

9. Мөн тэнд

10. Мөн тэнд

11. Мөн тэнд

лийн арга ажиллагаа бүхий нэхмэл эдлэл олдсон явдал үүнийг гэрчилж байна. Эртний түүхийн сурвалж бичгийн баттай мэдээгээр МЭӨ I зууны үед Да Вань (Ферган), Киргиз, Кушан, Хүннү¹², Гао Чань зэрэг газар оронд усан үзмийг өргөнөөр тариалдаг байжээ. Эдгээрийн дотроос Гүй цзы улсын (эртний угсаатны овог дотор нэг өрх айл 1000 ху* усан үзэм хадгалдаг. Давань — Ферганы улсын айл өрх усан үзмээр сайн чанарын дарс нэрдэг байсан бөгөөд баян язгууртан өрх айл нь 10,000 дан дарс хадгалдаг. Ферганы усан үзмээр нэрсэн дарс нь арван жил болсон ч мууддаггүй, сайн чанараа хадгалж чаддаг гэж тэмдэглэжээ.¹³ Хан улсын элч Ферганд очиж усан үзмийн модны үрийг авчирч хан улсад тариалж, үржүүлсэн усан үзэм ийнхүү тариалах болсон байна.

Энэхүү түүхийн эртний тулгуур материалд Хүннү улсын нутагт усан үзэм өргөнөөр тариалдаг гэж бичсэнээс үзэхэд одоогоос 2000 гаруй жилийн өмнө Хүннүгийн уугуул нутаг одоогийн БНМАУ-ын нутагт болон Өвөр Монголын цаг улирлын байдал урин дулаан байсан хэсэгт үнэхээр үзэм тарьж байсны баримт байх юуны магад. Тэр үед Хүннү нарын дунд усан үзэм төдийгүй бусад зарим үр жимс, ногоо, үр тариа зэрэг хүний хүнсний хэрэгцээний жимс жимсгэнэ, янз бүрийн сонгино сармис зэрэг бас багагүй байжээ. Бүр сүүлд 18-р зууны үед Монгол нутаг дээр Уйгур улсын оршин тогтнож байсан цагт ч энд мөн цаг уур дулаахан, янз бүрийн хээрийн жимс жимсгэнэ, арвайн гурил, шар будаа гэх мэтчилэнгийн үр тариа хэр зэрлэгээрээ нэлээд ургадаг байсан нь хүмүүсийн амьдралын хэрэгцээг хангадаг байжээ.

Хан улсын уди хаан өөрийн элч Ли Куаньли-г Ферган руу олон цэрэгтэй мордуулж, тэндээс 3000 гаруй агт морьдыг олзлон авч, мөн Ферганаас гаралтай царгасны үрийг¹⁴ авч ирсэн байна. Энэ үеэс эхлэн царгас Хятад нутагт бий болсноор олон газар өргөнөөр тариалах болжээ. Царгасын шинэхэн соёог хүнсний ногоо болон идшинд хэрэглэж болно. Царгас нь ургаж торнихдоо олон жижиг боргоцойтой болох бөгөөд боргоцой нь боловсрохын хирээр өнгө нь харлаж, дотор нь шар будаа хэлбэртэй чөмөг боловсроно. Энэхүү боловсорсон чөмөгөөр нь дарс нэрж болох ба удаан хугацаагаар хадгалж хүнсэнд хэрэглэдэг. Бас царгас нь малын сайн чанарын тэжээл болоод зогсохгүй сайн бордоо хийх түүхий эд, болдог.

Анар-гранатыг нь мөн баруун орнуудаар Чжань Цзян явж байхдаа Аньси улсаас үр авчирч тариалжээ.¹⁵ Энэ Анар жимсийг Аньси, Энэтхэг болон Өмнөт Далайн орнуудад ихээр тарьдаг. Анар нь сайхан амт тай, хүний цангаа гаргахаас гадна дарс нэрж болдог, бас эмийн найрлаганд орж өвчин анагаадаг Анар нь амтлаг, шар өнгөтэй, Чжань Цзянь анараас гадна цармын маалинга, хушиг, вандуй, өргөст хэмх, гүнжид, үнэрт ногоо, сармис зэргийн үрийг Ферганаас авчирсан байна.

Хушига нь Персээс гаралтай, Перс хунига нь яс нимгэн, идээ ихтэй, идэхэд нэн амттай. Вандуй баруун газрын улс орнуудаас гаралтай, түүнийг Хятад хүмүүс цаньдоу, ваньдоу, лудоу гэх мэтчилэнгээр нэрлэж иржээ. Энэхүү буурцаг нь бүгд вандуйн төрөлд багтах ургамал юм. Өргөст хэмхийг Усунь, Хүннү¹⁶, Кушан зэрэг улс оронд тариалж байжээ. Үүнийг хятадууд авч хэрэглэхдээ хугаа, (Ху нарын гуа гэх буюу хуан (шар) гуа хэмээн нэрэлдэг. Үнэрт ногооны зүйлээс хуцай, яньцай, сянь-

12. Мөн тэнд

*. 1 ху нь 51,7 ли

13. Мөн тэнд

14. Мөн тэнд

15. Мөн тэнд

16. Мөн тэнд

цай гэж нэрлэж навч болон үрийг нь хүнсэнд хэрэглэж байжээ. Хусуань гэж сармисыг хэлж байв. Үүнээс гадна лууванг бас л баруун орнуудаас үрийг нь авчээ. Сонгино Самираас, хар перец Энэтхэгээс, ар үр Персээс тус тус гаралтай гэж бичсэн байдаг. МЭӨ II зууны үед хан улс нь баруун орнууд гэж Хятадын эртний бичигт тэмдэглэгдэж ирсэн, энэхүү баруун орнуудын эдийн засаг, соёл нь тухайн үед өндөр хөгжилтэй байсан учир Хан улс нь тэндээс олон зүйлийг сурч, мэдэж авахын тулд тийш нь олон хүний бүрэлдэхүүнтэй элч төлөөлөгчдийг илгээж байв. Баруун орнуудын хүмүүсийг сиюй хүн гэж нэрлэж байсан билээ. Тэр үед Төв Азид Хүннү улс одоогийн БНМАУ-ын нутаг дэвсгэрээр төв болгон оршин тогтнож байв. Хятадын эртний судар бичигт Хүннүг Ху хэмээн тэмдэглэсээр иржээ.

МЭӨ —II зууны үед баруун орнуудаас Хятадад нэвтэрэн дэлгэрч байсан амтат жимс, хүнсний ногоо, үр тарианы зүйлийн үндсэн нэрийнх нь өмнө нэмж, дээр өгүүлсэн ху гэдэг нэр үгийг хэрэглэдэг байжээ. Үүнээс ажиглаж үзвэл уг үр тариа, жимс, ногооны төрлийн зарим нь анх нүүдэлчин ху нарын нутагт ургадаг байжээ. Гуа-өргөст хэмх, өмнө нь ху гэдэг үсэг нэмээд хугуа, суань сармис өмнө нь ху нэмээд хусуань, лобүглууван, өмнө нь ху нэмээд ху лобү, ма-олос өмнө нь ху нэмээд хума, тао-туу өмнө нь ху нэмээд хутао, чжао-гашуун ногоо, Өмнө нь ху нэ мээд хучжао, цунь-сонгино, өмнө нь ху нэмээд хуцунь болгожээ. Эдгээрийн нэлээд нь бүгд Хятад оронд баруун орнууд болон Ху нараас нэвтрэн дэлгэрсэн гэж хятад сурвалж нотлож байна. Доу гэж буурцаг, үүний өмнө нь ху гэдэг үг нэмээд худоу болгожээ. Энэхүү ху гэсэн (Төв Азид Өнө эрт цагаас нэр нь гарч байсан, нүүдэлчин ху нарыг хэлдэг. Өөрөөр хэлбэл Хүннү нарыг хэлдэг) дүрс үсгийг буурцагийн өмнө нэмэхэд уг буурцаг гэсэн утга огт өөрчлөгдөхгүй хэвээр байна. Харин уг ху гэдэг нэр өмнөө авч хэрэглэсэн нь уул зүйл хаанахыг болохыг өөрөө аяндаа тодотгон өгч байгаа бололтой. Дээр өгүүлсэн баруун орнуудаас ирж байсан ноосон эдлэл, жимс, хүнсний ногоогоор хязгаарлагдахгүй, Хүннүгийн хурдан морьд, хоёр бөхөт тэмээ, илжиг, луус зэрэг мал мөн мал маллах нарийн арга ухаан, төрөл бүрийн ан амьтан, эрдэнийн чулуу, амтлаг сайхан дарс, ху нарын хувцас хунар, цагаан архи, ферганы усан үзмийн амтлаг дарс, тэргүүтэн Дорнодахины Хятад зэрэг улс оронд, дэлгэрчээ.

Баруун хязгаарын хүмүүс Дорно зүгийн Хятад зэрэг улс оронд тасралтгүй ирсээр байв.

Хан улсын үед ху хүмүүсээс хятадад ирсэн хамгийн анхны хүн бол хүннүгийн Суту вангийн хүү Жинжиди юм. Суту ван Хан улсад бууж өгөөгүй учир алагдаж, түүний хүү болон эхнэрийг Хан улс олзлон авчээ. Хан улс Суту вангийн тэнгэр тахидаг алтан (хүнийг) бурханыг олзолж аваад түүний хүүд Суту гэдэг эцгийнх нь нэрээр овоглуулаагүй, харин Суту вангаас олзолж авсан алтан бурханы Алт-жин гэдэг хятад овгийг Жиди-д өгсөн учраас Жинжиди нэртэй болгосон гэж түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. Хан улсын уди хаан болон ордоныхон Жинжидигээр морь-маллах арга ухааныг заалгаж байсан учир Хятадын өөрийн нь сурвалж бичиг-ном сударт энэ үеэс эхлэн нүүдэлчдийн-хүннүгийн адуу маллах арга ухаан---хятад оронд анх нэвтрэн дэлгэрсэн гэж нотолдог.

МЭӨ. I зууны үед Ху нарын зочид төлөөлөгчид Хятадын баруун хан улсад их хэмжээгээр ирж байжээ. Тэдгээр Ху-зочид төлөөлөгчид нь зэрлэг ан амьтдыг тоглуулж хан улсын хаад, ноёд, язгууртнуудын анхаарлыг гойд их татаж байжээ. Энэ тоглолт нь үнэн чанартаа хүн ба зэрлэг амьтаны хоорондох тулалдаан болж байжээ. Хожим нь Ху нарын энэхүү зэрлэг амьтан тоглуулж байсан байдал нь Баруун, Зүүн Хан

улсын байшин барилгын хана туурганы чулуун сийлбэрт бий болсны зэрэгцээ тэр үеийн Хятадын сийлбэрийн урлагийн гол дүрслэл дүрийн нэг болон үлдээжээ. МЭӨ I зууны сүүлчээр санскрит хэлний эрдэмтэд Кушан, Энэтхэг, Иран, Киргиз зэрэг олон орноос Дорно зүгт-Хятадад олноор ирж, бурхны ном судар орчуулж байжээ.

Баруун хан улсын сүүлч үеийн хан Аидийн үед Кушаны элч Ицун буддын шашны сургаал номыг Хятадад дэлгэрүүлж, багшийн шавь Жинлу нь бас энэхүү элчээс бурханы сургаалын ном тайлбарлаж байхыг сонссон нь Хятадад бурханы сургаалын ном нэвтрэх анхны эхлэл мөн»¹⁷ гэсэн байна. Харин Хүннүгийн Суту вангаас Хан улсын олзолж авсан Алтан бурхан нь үүнээс их олон жилийн өмнө болсон үйл явдал, чухам тэр алтан бурхан нь бараг Хятадад Хүннүгээс нэвтэрсэн анхны бурхан болох юм. Түүнээс өмнө Хятадад бурхан шашин нэвтэрсэн мэдээ хараахан олдоогүй байна.

Хан улсын элч Чжан Цзянь 2-дахь удаагаа баруун хязгаараар яваад буцах үед нь, ферганы нэг элч Ромын вант улсын «Хутга залгиж, галаар бөөлждөг, модыг жимс болгодог, хүн алж, морь огтлон» байгаагаар үзүүлж чаддаг илбэчин дагуулан явж байжээ.¹⁸ Бас үүнээс гадна Төв Азийн хөгжмийн зэмсэг, хөгжмийн нот, дуу бүжиг, сийлбэр, уран зураг зэрэг урлаг нь энэ үед удаа дараалан Хятадад нэвтэрч байсан нь Хятадын соёл урлагийн хөгжилд үр ашигтай болсон гэж тэмдэглэгдэн үлджээ.¹⁹

17. Хятадын эртний түүх, тэргүүн боть. 1979 он. Бээжин. (хятад хэлээр) 393-р тал.

18. Мөн тэнд

19. Мөн тэнд